



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Бат-Эрдэнэ

Утас: 99979261

Цахим хаяг: Bat-erdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.25 № 2/122

танай _____ -ны № _____ -т

ЦЭЦЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Нэгтгэлд хамрагдсан сумын Засаг даргын тамгын газарт 2024 оны санхүүгийн тайланг Төрийн аудитын газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй тул татгалзсан дүгнэлт гаргасан;
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлуудын санхүүжилт, урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлээр олгоогүй;
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн тайлант онд санхүүжилт олгосон 57 ажлын 2,103,506.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажилд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй;
- ОНХС-ийн хөрөнгөөр "Баяр наадмын талбайн засвар шинэчлэлийн ажил"-ын төсөвт өртгийг 361,817.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн

- ОНХС-ийн хөрөнгөөр сумын угтах хаалга тохижуулж, үр өгөөж муутай хөрөнгө оруулалтын 35,000.0 мянган төгрөгийн ажил санхүүжүүлсэн
- Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүс болон аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийг 14.752,5 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцсон.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цэцэг сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 1,057,596.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 370,369.6 мянган төгрөг буюу 53,9 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,368,592.9 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

ХОЁР. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН***(мян.төгрөгөөр)*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,408,656.60	3,448,864.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,224,036.40	1,520,785.50
33	АВЛАГА	1,132,317.20	1,775,428.40
34	УРЬДЧИЛГАА	-	101,613.10
35	БАРАА МАТЕРИАЛ	52,303.10	51,037.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,281,435.00	8,609,820.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,281,435.00	8,609,820.00
39200	Биет хөрөнгө	8,276,741.00	8,595,126.00
39300	Биет бус хөрөнгө	4,694.00	14,694.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,690,091.60	12,058,684.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,830.50	85,701.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,830.50	85,701.80
41300	Өглөг	30,830.50	85,701.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,659,261.20	11,972,982.90
51	Засгийн газрын хувь оролцоо	10,659,261.20	11,972,982.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	856,592.60	856,592.60
51200	Хуримтлагдсан үр дүн	9,526,273.20	10,839,994.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	276,395.40	276,395.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,690,091.60	12,058,684.60

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН*Төгрөгөөр*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,626,032.20	6,657,068.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,078,783.00	1,032,188.80
110	Орлогын албан татвар	360,849.00	768,487.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	385,284.70	798,463.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,435.70)	(29,975.70)
113	Хөрөнгийн албан татвар	24,860.70	32,485.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	693,073.20	231,215.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,482,387.70	2,667,916.70
120	Нийтлэг татварын бус орлого	2,462,764.40	2,626,212.80
121	Хөрөнгийн орлого	19,623.30	41,703.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,064,861.50	2,956,963.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,096,010.50	5,288,408.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,950,071.50	5,288,408.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,370,286.10	5,249,539.80

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	485,693.90	750,037.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,020.10	94,231.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,316.10	1,150,147.90
2104	Хангамж, бараа материалын зардал	1,526,087.70	1,646,281.60
2105	Нормативт зардал	502.20	6,564.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,153.50	8,071.00
2107	Томилолт, зочны зардал	9,489.90	9,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	435,113.30	64,320.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	684,909.50	1,520,875.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,579,785.40	38,869.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145,939.10	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,530,021.60	1,368,659.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100.00	15,150.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,529,921.60	1,353,509.70

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,525,687.50	5,867,928.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,078,783.00	1,032,188.80
110	Орлогын албан татвар	360,849.00	768,487.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	385,284.70	798,463.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,435.70)	(29,975.70)
113	Хөрөнгийн албан татвар	24,860.70	32,485.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	693,073.20	231,215.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	111,398.40	35,398.70
1181	Газрын төлбөр	214,787.80	93,937.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	366,887.00	101,879.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,384,420.60	1,878,776.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,364,797.20	1,837,072.60
121	Хөрөнгийн орлого	19,623.30	41,703.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,062,484.00	2,956,963.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,243,312.50	3,294,575.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,243,312.50	3,294,575.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,660,386.00	3,255,439.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	524,389.10	816,964.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,324.30	109,675.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,058.60	1,165,829.30
2104	Хангамж, бараа материалын зардал	30,755.90	46,872.00
2105	Нормативт зардал	502.20	553.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,954.30	9,110.70
2107	Томилолт, зочны зардал	9,489.90	9,899.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	502,610.00	108,105.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	410,301.70	988,429.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,582,926.50	39,136.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,282,375.00	2,573,352.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,971,631.30	2,237,611.40

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,971,631.30	2,237,611.40
2200	Дотоод эх үүсвэрээр	1,971,631.30	2,237,611.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,971,631.30)	(2,237,611.40)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(80,100.00)	(38,992.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	80,100.00	38,992.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	230,643.70	296,749.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	993,392.70	1,224,036.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,224,036.40	1,520,785.50

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,283,706.60	4,006,287.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,878,660.10	1,729,684.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,839,446.10	1,690,548.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	760,833.00	754,670.26
210101	Үндсэн цалин	406,970.70	405,286.34
210102	Нэмэгдэл	270,754.20	266,593.89
210104	Урамшуулал	43,508.10	43,507.65
210105	Гэрээт ажлын хөлс	39,600.00	39,282.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,104.00	94,575.14
210201	Тэтгэврийн даатгал	64,670.80	64,670.80
210202	Тэтгэмжийн даатгал	7,608.30	7,502.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,352.10	5,281.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,256.10	2,185.80
210205	Эрүүл мэндийн даатгал	15,216.70	14,934.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	693,156.60	657,482.30
210301	Гэрэл, цахилгаан	36,801.30	36,496.84
210302	Түлш, халаалт	652,315.20	617,326.15
210303	Цэвэр, бохир ус	4,040.10	3,659.30
2104	Хангамж, бараа материалын зардал	27,618.50	27,618.50
210401	Бичиг хэрэг	3,399.20	3,399.20
210402	Тээвэр, шатахуун	20,156.30	20,156.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,063.00	4,063.00
2105	Нормативт зардал	553.70	553.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553.70	553.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,110.70	9,110.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317.00	317.00
210604	Урсгал засвар	8,793.70	8,793.70
2107	Томилолт, зочны зардал	10,945.10	9,899.40
210702	Дотоод албан томилолт	10,945.10	9,899.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,497.50	52,278.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,218.50	49,999.18
210803	Даатгалын үйлчилгээ	346.00	346.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300.00	300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34.00	34.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,291.50	1,291.50
210807	Газрын төлбөр	307.50	307.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	189,627.00	84,360.20

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	186,817.20	81,550.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,809.80	2,809.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,214.00	39,136.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,214.00	39,136.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,302.00	37,302.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,912.00	1,834.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,345,046.50	2,237,611.39
220001	Барилга байгууламж	2,459,830.20	1,491,272.84
221001	Их засвар	163,602.00	50,969.91
222001	Тоног төхөөрөмж	411,281.30	401,165.90
223001	Бусад хөрөнгө	310,333.00	294,202.74
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	60,000.00	38,992.00
230001	Эргэж төлөгдөх зээл	60,000.00	38,992.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,283,706.60	3,955,095.58
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,206,322.50	2,306,635.75
320001	Орон нутгийн төсвөөс	1,748,405.00	1,848,718.25
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	457,917.50	457,917.50
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,077,384.10	1,648,459.82
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.00	450.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,704,648.60	1,648,009.82
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,372,130.50	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	604,824.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	553,632.28
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	66.00	66.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	32.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан	5.00	5.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,032,947.70	9,032,947.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	96,391.80	96,391.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,129,339.50	9,129,339.50
9	Тайлант үеийн үр дүн	1,529,921.60	1,529,921.60
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,659,261.20	10,659,261.20
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,659,261.20	10,659,261.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(39,788.00)	(39,788.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,619,473.20	10,619,473.20
19	Тайлант үеийн үр дүн	1,353,509.70	1,353,509.70
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,972,982.90	11,972,982.90

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 2,628,967.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 113,891.9 мянган төгрөгийн алдаа, 2,515,076.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Нийт зөрчлийн нэгтгэл нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, нэгтгэлд хамрагдсан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд ирүүлээгүйгээс татгалзсан дүгнэлт гарсан зэрэг нөлөөлийг тооцон “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ Мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	
ИТХ											
ЗДТГ	1	25,035.5		-	1	25,035.46	1	25,035.46			
ОНХС	3	74,103.9	3	74,103.9			3	74,103.9			
ХХС	1	14,752.5	1	14,752.5			1	14,752.5			
“Мянган сүтэйн буян” ОНӨААТҮГ											
Дүн	5	113,891.9	4	88,856.4	1	25,035.5	5	113,891.9	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	Хөрөнгө оруулалтын ажлуудын санхүүжилт, урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлээр олгоогүй	1	-					1	-		
	Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажилд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй.	1	2,103,506.3					1	2,103,506.3		
	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөвт өртгийг нэмэгдүүлсэн 361,817.2 мянган төгрөгийн, үр өгөөж муутай хөрөнгө оруулалтын 35,000.0 мянган төгрөгийн ажил тус тус санхүүжүүлсэн	1	396,817.2					1	396,817.2		
ХХС	Хувь хүмүүст олгосон зээлийг буруу тооцсон	1	14,752.52					1	14,752.52		
	Дүн	4	2,515,076.0	-	-	-	-	4	2,515,076.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТӨҮГ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1					1	
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1					1	